

ЭРДЭНЭЦАГААН СУМ

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

Хууль, эрх зүй, удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

2023.04.21-нд [Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал](#), Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "Сонсох ажиллагаа" нээлттэй хэлэлцүүлэг болж өндөрлөлөө.

Хэлэлцүүлэгт:

- ИТХ-н Байгаль орчин хөдөө аж ахуйн хөгжлийн хороо хяналт шалгалт хийсэн талаарх мэдээлэл,
- Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн албан хаагч холбогдох мэдээлэл,
- Уул уурхайн Эрдэнийн босго, Андын Илч, Бадмаараг хаш, Эрээн толгой, Номин богд зэрэг 5 компаний тайлан мэдээлэл хийгдлээ.
- Нийт сумын 86 иргэний төлөөлөл оролцож 22 иргэн санал хүсэлт гаргаж асуусан асуултандаа холбогдох компаниас хариултаа авлаа. Иргэд 100%-н саналаар хатуу хучилттай замын асуудлыг шийдвэрлэсний дараа Уул уурхайн компаниудын үйл ажиллагааг явуулах шийдвэр дээр санал нэгдлээ.

Хэлэлцүүлгээс гарсан шийдвэр:

Уул уурхай, компаниудад хатуу хучилттай замыг тавих шаардлага хүргүүлж ажлын 5, амралтын 2 нийт 7 хоногийн дотор албан бичгээр хариу ирүүлэх үүрэг даалгавар өглөө. Шаардлагын хариуг хугацаандаа ирүүлээгүй тохиолдолд дараагийн шатны арга хэмжээ авахаар болов.

Зүүн болон говийн бүсийн 7 аймгийн “Тогооч нарын ур чадвар”-н уралдаанд 7 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, “Орон нутгийн онцлогтой хоол унд”-ны төрөлд 1-р байр Алтан медаль, “Зөөгчийн төрөл”-д 3-р байр хүрэл медаль хүртэж амжилттай оролцсон. Засаг даргын нөөц сангаас 600,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Шүүр ажиллагааны хүрээнд 7 Төрийн болон төсөвт байгууллагын тайланг хүргүүлсэн. 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн А/39 дугаар захирамжаар байгуулагдсан “Зөвлөл” жилийн ажлын хүрээнд төлөвлөгөөт шалгалтыг 1,2-р цэцэрлэг, ЕБС зэрэг байгууллагуудад хийлээ.

ЕБС: Японы Хүүхдийн Ивээх Сан (ЯХИС) нь Боловсрол, Шинжлэх Ухааны яамтай хамтран "Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар,

энтрепренершип боловсрол олгох" төслийг Дэлхийн банкны менежменттэйгээр хэрэгжүүлж байна.

Сургуульд суурилсан энтрепрайс "Технологийн хичээлээр сурагчдад болон өсвөр үеийнхэнд энтрепренершип боловсрол олгох төслийн хүрээнд нийт 115.000.000 тоног төхөөрөмж хүлээн авч үйл ажиллагаа нь хэвийн явагдаж үйлдвэрлэл эхэлж бүтээлүүд гарсаар байна. Мөн төслийн хугацаанд 12 багш сургагч багшаар бэлтгэгдсэн.ЕБС, НТБ-ын нийт 7 ангид 160 гаруй суралцагч хамрагдсан байна.

2 удаагийн PITCH EVENT зохион байгуулагдаж 11 төсөл орсноос ЕБС-ийн 2, НТБ-ын 3 төсөл шалгарч тус бүр 2,8 сая төгрөгийн санхүүжилтээ авч амжилттай хэрэгжиж байна.

ЕБС-ийн Эрэгтэй Эмэгтэй технологийн хичээлийн танхимын нээлт. амжилттай боллоо.Хэрэгжиж буй төсөл болон Esel хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагаанд мониторинг хийгдэж байна.

Хүүхэд хэгжил хамгааллыг дэмжих жилийн ажлын хүрээнд аймгийн ГБХЗХГ-аас БШУГ, Монголын урлагын сэтгэл заслын мэргэжлийн холбооны Арт терапевст В.Бэрцэцэг хамтран зохион байгуулсанажлын байран дах стрессээ бууруулах, үе тэнгийн дээрэлхэлт ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх сургалтад нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, дотуур байрны 2 багш хамрагдаж чадавхжлаа.

ЗҮҮН БҮСИЙН МАТЕМАТИКИЙН 6-Р ОЛИМПИАДАД 8-р ангийн сурагч Дөл Мөнгөн медаль хүртэж амжилттай оролцлоо. "ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫГ ДЭМЖИХ ЖИЛ"-ийн хүрээнд Аймгийн хүүхдийн Анхдугаар спортын наадамд баг хамт олноороо амжилттай оролцсон

Санхүүгийн чиглэлээр:

2023 оны 4-р сарын орлогыг хааж төвлөрүүлсэн байдал:

1. Цалин, хөлс түүнтэй адилтгах орлого -224,021,345.33
2. Үйл ажиллагааны орлого – 954,792.66
3. Хөрөнгийн орлого -15,131,026.37
4. Шууд бус орлого – 75,630571.48
5. Малын тоо толгойд огдуулах албан татвар – 27,394,900
6. Бууны албан татвар – 534,000

7. ҮХХАТ- 7,958,918.84
8. Бууны албан татвар – 534,000
9. Улсын тэмдэгтийн хураамж- 875,800
- 10.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр – 372,000
- 11.Газрын төлбөр- 11,673,813
- 12.Торгуулийн орлого – 9,594,000 нийт 12 нэр төрлийн 374,141,167.68

төгрөгийн орлого төвлөрүүлэн хаалтыг хугацаанд хийж орлогыг 32%-ийн биелэлттэй төвлөрүүлэн ажиллаа. Аймгийн санхүүгийн дэмжлэг хувиараар 185,810,300 төгрөгийн санхүүжилт ирсэнээс орон нутгийн 3 байгууллага, ТЗШ-ын 5-н байгууллагад 432,996,900 төгрөгийн санхүүжилтийг олгож, 2023 оны 4-р сард 576 ширхэг гүйлгээг хянаж батлан 3,908,428,953 төгрөгийн гүйлгээ хийгээд байна.

Мэдээлэл технологийн ажлын хүрээнд:

- “Засаг даргын тамгын газар” пэйж хуудасаар дамжуулж цаг үеийн мэдээ мэдээллийг нийтэлж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллаа.
- ОНХСангийн хөрөнгөөр тамгын газрын дотоод интернет сүлжээг шинэчлэж, холболтыг хийж сайжруулсан.

Е-Mongolia.mn, Төрийн үйлчилгээний цахим системийн хүрээнд:

Д/д	Үйлчилгээний тоо			Хамгийн их үзүүлсэн 10 үйлчилгээ	
	Нийт	Төлбөртэй	Төлбөргүй	Нэр	Тоо
1	10		8	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт	8
2			1	Гэрлэсний бүртгэлийн лавлагаа	1
3		2		Зээлийн мэдээллийн лавлагаа – Бүрэнскор (Иргэн)	2
4			4	Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа	4
5			4	Иргэний үнэмлэхийн лавлагаа	4
6		1		Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт	1

7		1		Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт	1
8			2	Овог, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний лавлагаа	2
9		2		Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт (Иргэн)	2
10			1	Эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах	1
Нийт		6	20		26

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын хэмжээнд төл малын мэдээ 144522 толгой эх мал төллөж 70.3 хувьтай, малын хорогдлын мэдээ 478 толгой мал хорогдсон байна.

Багуудаас ирсэн судалгаагаар гадны өөр аймаг сумдаас 19 өрх 17650 толгой мал ирж өвөлжиж хаваржиж байна.

Гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр

ГБХ-тэй холбоотой 1 кейсийг үйлчүүлэгчийн хаах хүсэлтийн дагуу холбогдох материалыг бүрдүүлж аймгийн ГБХЗХГ-т хүргүүлэв.

Жендерийн хэвшмэл ойлголтыг арилгах, эмэгтэйчүүдийн манлайлал, нийгэмд үзүүлэх үр нөлөөг сурталчлан таниулах, эрэгтэй эмэгтэй хүмүүст тулгарч буй жендерийн асуудлын талаар мэдээлэх зорилгоор жендерийн үндэсний хорооноос санаачлан Надаас, танаас, биднээс эхлэлтэй уриан дор "Харилцан хүндэтгэе" аяны хүрээнд хийсэн ажлын тайланг нэгтгэж аймгийн НБХ-т явуулав.

Сумын Засаг даргын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт нь 6 заалттай сүүлийн 5 жилд гаргасан санхүү төсвийн зардал хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын тайланг хийж ГБХЗХГ-т явуулав.

“Эрүүл аюулгүй ажил-Бидний суурь эрх” уриан дор “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аян 2023” аян 04-р сарын 01-нээс 04-р сарын 30н хүртэл

аймгийн хэмжээнд зохион байгуулж байна. Аянтай холбогдуулан сумын дэд зөвлөлийг шинэчлэн байгуулж тус аяны хүрээнд байгуулага бүр тодорхой ажлыг зохион байгуулах засаг даргын албан тоотыг гаргаж байгууллагуудад хүргэж ажилласан.

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11-р сард гарсан хувийн хэрэг шинэчлэх 600-р тогтоолын дагуу байгууллагын албан хаагч нарыг хувийн хэргийг шинчиллээ.

Гадаад улсад оршин суугаа гишүүнтэй өрхийн нөхцөл байдлын судалгаа ирсэнийг тодруулж Статистикийн хэлтэст явуулав.

Соёлын чиглэлээр:

Алслагдсан хил орчмын 8 заставын бие бүрэлдэхүүн түүний гэр бүл болон хугацаат цэргийн алба хаагчдад явуулын 6 төрлийн үйлчилгээг үзүүлж үйл ажиллагаанд нийт 14 объект, 288 хүнд хүрч ажиллалаа.

Сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар Егүзер хутагтын музей,Хатагины хар сүлдний тахилгын өргөөнд 4 ширхэг хяналтын иж камерыг Энх Өргөний Гол ХХК-иар гүйцэтгүүлэн ажиллалаа.

Тайлан бичсэн: ХЭЗ,ХШҮ- хариуцсан мэргэжилтэн Д.Жагварал.